



**БАЯНХОНГОР АЙМГИЙН
ЖИНСТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2022 оны 09 сарын 20 өдөр

Дугаар А/105

Бодь

Шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх
намрын дархлаажуулалтын ажлыг яаралтай
зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, Мал амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3, 9.5-9.8 дахь хэсэг, Улсын онцгой комиссын 2022 оны 03 дугаар сарын 23-ны өдрийн 02 дугаар тогтоол, “Шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтын ажлыг зохион байгуулах тухай” Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын 2022 оны 09 дүгээр сарын 08-ны өдрийн А/191 дугаар тушаал, аймгийн Засаг даргын 2022 оны 09 дүгээр сарын 15-ны өдрийн А/585 дугаар захирамж, аймгийн Мал эмнэлгийн газрын даргын А/27 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Тус сумын нутаг дэвсгэрт байгаа үхэр сүргийг гоц халварт шүлхийн өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтын ажлыг хуулийн хугацаанд нь шуурхай зохион байгуулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг баталсугай.

2.Шүлхийн өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтын арга хэмжээг хуваарийн дагуу, технологи хугацаанд нь шуурхай зохион байгуулахыг аж ахуйн нэгжүүдийн малын эмч нарт үүрэг болгосугай.

3.Дархлаажуулалтын ажлыг мэргэжил арга зүйгээр болон, заавар зөвлөмжөөр хангаж хяналт тавьж ажиллахыг Мал эмнэлгийн хяналтыг Улсын байцаагч (А.Лхагвабаяр)-д дааласугай.

4.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргыг орлогч (Н.Сумъяа)-д даалгасугай.

ДАРГА



Р.БАТЖАРГАЛ

642201205

Сумын Засаг даргын 2022 оны 09
дүгээр сарын 20 -ны өдрийн 4/105 тоот
захирамжийн ... дүгээр хавсралт

Ажлын хэсгийн бүрэлдэхүүн

Ахлагч

А.Лхагвабаяр

(Мал эмнэлгийн тасгийн Улсын байцаагч)

Г.Эрдэнэтөр

(Мал эмнэлгийн тасгийн тархвар зүйч)

Ж.Лхагвабаяр

(Уу булан 1 дүгээр багийн Засаг дарга)

Б.Наранбаатар

(Хүйс 2 дугаар багийн Засаг дарга)

У.Батцэцэг

(Хөнөг 3 дугаар багийн Засаг дарга)

Б.Мөнхбат

Цагаан ус 4 дүгээр багийн Засаг дарга

Б.Ганцэцэг

(Бодь 5 дугаар багийн Засаг дарга)

С.Эрдэнэ

(“Дундаршгүй баялаг” ХХК-ны малын их эмч)

Б.Цэрэн-Очир

(“Эрдэнэт таван богд” ХХК Малын их эмч)

оОо